ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/069/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 241

танай 2025.01.22 -ны № 8 -т

ДОРНОД АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЧИМЭДДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022035

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Биеийн тамир спортын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Биеийн тамир спортын хорооноос 98.2 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **186,950,489.00** | **293,263,286.00** |
| **33** | **АВЛАГА** | **5,195,100.00** | **2,200,000.00** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 400,000.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 1,800,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,195,100.00 | 1,800,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **181,755,389.00** | **291,063,286.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **173,950,100.00** | **182,179,600.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 173,950,100.00 | 182,179,600.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | 98,849,659.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **7,805,289.00** | **10,034,027.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,595,950.00 | 1,170,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,114,339.00 | 6,466,577.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 339,000.00 | 1,274,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 108,000.00 | 108,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 648,000.00 | 1,015,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,288,402,901.66** | **3,293,471,617.59** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,288,402,901.66** | **3,293,471,617.59** |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,067,161,359.84 | 2,072,626,075.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,533,062,107.00 | 1,563,062,107.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (114,452,493.74) | (141,856,239.74) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 40,000,000.00 | 40,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (16,999,999.83) | (20,999,999.79) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 124,938,860.00 | 131,688,860.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (62,400,952.83) | (81,833,832.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 165,354,798.00 | 200,354,798.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (130,549,272.25) | (145,207,046.95) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 550,969,683.26 | 567,924,783.26 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (417,761,369.77) | (435,507,353.35) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 395,000,000.00 | 395,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,221,241,541.82 | 1,220,845,541.82 |
| 39301 | Програм хангамж | 3,520,000.00 | 3,520,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,343,458.18) | (2,739,458.18) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,220,065,000.00 | 1,220,065,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,475,353,390.66** | **3,586,734,903.59** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **400,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | **400,000.00** |
| **413** | **Өглөг** | - | **400,000.00** |
| 41360 | Бусад өглөг | - | 400,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,475,353,390.66** | **3,586,334,903.59** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,475,353,390.66** | **3,586,334,903.59** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 948,225,000.00 | 948,225,000.00 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 948,225,000.00 | 948,225,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,708,047,448.00 | 1,708,047,448.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 185,199,006.16 | 296,180,519.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (3,290,154,384.50) | 185,199,006.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,475,353,390.66 | 110,981,512.93 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 633,881,936.50 | 633,881,936.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,475,353,390.66** | **3,586,734,903.59** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,506,628,613.11** | **1,785,356,859.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,506,628,613.11** | **1,785,356,859.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,219,206,752.11** | **0.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 3,119,867,447.11 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 99,339,305.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,287,421,861.00** | **1,785,356,859.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 612,785,500.00 | 721,739,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 612,785,500.00 | 721,739,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 644,476,361.00 | 1,026,190,359.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | - | 1,006,377,159.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 643,356,361.00 | 19,813,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,120,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 30,160,000.00 | 37,427,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 30,160,000.00 | 37,427,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **961,331,466.87** | **1,674,375,346.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **961,331,466.87** | **1,674,375,346.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **950,870,098.67** | **1,649,872,314.10** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **365,830,326.13** | **506,518,899.60** |
| 210101 | Үндсэн цалин | 220,306,772.37 | 268,872,065.98 |
| 210102 | Нэмэгдэл | 68,257,742.58 | 170,220,993.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,147,756.45 | 36,410,000.00 |
| 210104 | Урамшуулал | 42,118,054.73 | 31,015,840.29 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **45,748,100.00** | **63,314,899.81** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,272,529.53 | 43,711,992.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,679,122.00 | 5,142,586.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,943,296.00 | 2,959,513.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 728,334.00 | 1,872,676.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,124,818.47 | 9,628,132.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,351,419.67** | **26,079,679.88** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,187,002.83 | 4,446,556.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,614,416.84 | 16,661,528.88 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,550,000.00 | 4,971,595.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,229,048.00** | **9,513,105.74** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,298,100.00 | 1,596,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,160,741.00 | 2,448,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,511,847.00 | 1,395,872.74 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 748,085.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,658,360.00 | 3,324,248.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,939,000.00** | **5,971,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,939,000.00 | 5,971,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,498,400.00** | **2,405,140.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,498,400.00 | 2,405,140.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,728,015.00** | **544,027,735.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 253,200.00 | 535,723,410.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 555,025.00 | 740,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 59,500.00 | 59,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 360,000.00 | 343,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,194,290.00 | 7,161,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **492,545,789.87** | **492,041,854.07** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 412,735,683.00 | 408,405,470.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,810,106.87 | 83,636,384.07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,461,368.20** | **24,503,031.97** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,800,000.00 | 12,273,020.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 9,539,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,800,000.00 | 2,733,520.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 532,772.87 | 936,001.85 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 532,772.87 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | - | 936,001.85 |
| **2134** | **Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт** | **7,128,595.33** | **11,294,010.12** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,128,595.33 | 11,294,010.12 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,545,297,146.24** | **110,981,512.93** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)** | **69,943,755.58** | **-** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 69,943,755.58 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 29,499.58 | - |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | 69,914,256.00 | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,475,353,390.66** | **110,981,512.93** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **964,257,200.00** | **1,607,947,200.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **964,257,200.00** | **1,607,947,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **612,785,500.00** | **721,739,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 612,785,500.00 | 721,739,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **321,311,700.00** | **848,780,700.00** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | - | 828,967,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 320,191,700.00 | 19,813,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,120,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **30,160,000.00** | **37,427,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 30,160,000.00 | 37,427,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **964,257,200.00** | **1,607,947,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **964,257,200.00** | **1,607,947,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **953,795,831.80** | **1,583,444,168.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **365,830,326.13** | **506,518,899.60** |
| 210101 | Үндсэн цалин | 220,306,772.37 | 268,872,065.98 |
| 210102 | Нэмэгдэл | 68,257,742.58 | 170,220,993.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,147,756.45 | 36,410,000.00 |
| 210103 | Урамшуулал | 42,118,054.73 | 31,015,840.29 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **45,748,100.00** | **63,314,899.81** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,272,529.53 | 43,711,992.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,679,122.00 | 5,142,586.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,943,296.00 | 2,959,513.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 728,334.00 | 1,872,676.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,124,818.47 | 9,628,132.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,351,419.67** | **26,079,679.88** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,187,002.83 | 4,446,556.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,614,416.84 | 16,661,528.88 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,550,000.00 | 4,971,595.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,311,588.00** | **9,195,343.74** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,171,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,499,741.00 | 2,448,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,511,847.00 | 1,395,872.74 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 748,085.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,500,000.00 | 3,431,986.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **67,799,300.00** | **12,689,300.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 45,800,000.00 | 5,689,800.00 |
| 210602 | Тавилга | 20,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 1,999,300.00 | 6,999,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,498,400.00** | **2,405,140.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,498,400.00 | 2,405,140.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,868,015.00** | **544,388,935.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 253,200.00 | 535,937,610.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 555,025.00 | 740,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 59,500.00 | 59,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 500,000.00 | 490,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,194,290.00 | 7,161,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **429,388,683.00** | **418,851,970.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 429,388,683.00 | 418,851,970.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,461,368.20** | **24,503,031.97** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,800,000.00** | **12,273,020.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 9,539,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,800,000.00 | 2,733,520.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **532,772.87** | **936,001.85** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 532,772.87 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | - | 936,001.85 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **7,128,595.33** | **11,294,010.12** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,128,595.33 | 11,294,010.12 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,656,272,448.00** | **633,881,936.50** | **185,199,006.16** | **3,475,353,390.66** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,656,272,448.00** | **633,881,936.50** | **185,199,006.16** | **3,475,353,390.66** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 110,981,512.93 | 110,981,512.93 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,656,272,448.00** | **633,881,936.50** | **296,180,519.09** | **3,586,334,903.59** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 721,739,000.00 | 720,802,998.15 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 721,739,000.00 | 720,802,998.15 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 709,452,700.00 | 708,529,978.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 506,518,900.00 | 506,518,899.60 |
| 210101 | Үндсэн цалин | 265,269,400.00 | 268,872,065.98 |
| 210102 | Нэмэгдэл | 179,096,000.00 | 170,220,993.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,063,800.00 | 36,410,000.00 |
| 210104 | Урамшуулал | 35,089,700.00 | 31,015,840.29 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,314,900.00 | 63,314,899.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,054,100.00 | 43,711,992.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,065,200.00 | 5,142,586.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,532,600.00 | 2,959,513.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,532,600.00 | 1,872,676.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,130,400.00 | 9,628,132.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,649,100.00 | 9,195,343.74 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,177,200.00 | 1,171,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,452,500.00 | 2,448,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,506,800.00 | 1,395,872.74 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,079,100.00 | 748,085.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,433,500.00 | 3,431,986.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,689,800.00 | 10,689,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,689,800.00 | 5,689,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,452,500.00 | 2,405,140.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 2,452,500.00 | 2,405,140.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,751,700.00 | 10,393,935.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,962,000.00 | 1,942,610.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 235,400.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 744,600.00 | 740,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 93,200.00 | 59,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 64,700.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 490,500.00 | 490,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 7,161,300.00 | 7,161,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 106,075,800.00 | 106,011,960.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 106,075,800.00 | 106,011,960.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,286,300.00 | 12,273,020.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,286,300.00 | 12,273,020.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,539,500.00 | 9,539,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,746,800.00 | 2,733,520.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 721,739,000.00 | 720,802,998.15 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 721,739,000.00 | 720,802,998.15 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 721,739,000.00 | 720,802,998.15 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 21.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **848,780,700.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **848,780,700.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 846,835,010.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 533,995,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 533,995,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 312,840,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 312,840,010.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,945,690.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,945,690.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 848,780,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 848,780,700.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 828,967,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,813,200.00 |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.1 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс 3.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

### 2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогчид 90.0 хувиар тооцон 1.3 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. 2023 оноос үүссэн 1.8 сая төгрөгийн авлагатай байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг мөрдөөгүй санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 2023 оноос үүссэн авлагатай байна. | 1 | 1,800.0 | | | 1 | 1,800.0 | | | | | | |
| Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 160.0 хувиар тооцон олгосон | 1 | 1,323.9 | | | 1 | 1,323.9 | | | | | | |
| **Дүн** | **2** | **3,123.9** | | | **2** | **3,123.9** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроосон | 1 | - | | | | | 1 | - |
| **Нийт дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 2025/19125749 ДОА-2025/0691 НА-СТА-ПИЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2023 онд үүссэн Аймгийн засаг даргын А/189 дүгээр захирамжийн дагуу мэдээллийн самбарын төлбөр шилжүүлсэн боловч гэрээ хийгдээгүй, тайлант онд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэж дуусгаагүй 1.800.000.00 /нэг сая найман зуун мянган/ төгрөгийн авлагыг он дамжуулсан.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 4.1.6-д "Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт, эд хөрөнгийн улирал, жилийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг үндэслэн санхүүгийн тайлан тэнцэл гаргаж, батлагдсан төсвийн гүйцэтгэл, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн илтгэх хуудасны хамт Төсвийн тухай хуулийн 8.8, 8.9, 8.10-т заасан хугацаанд холбогдох байгууллагад хүлээлгэн өгч байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 *дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, авлагыг барагдуулан хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040341

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг ажиллахыг Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Б.Чимэддорж, нягтлан бодогч Б.Зул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 116/19125799 Чойбалсан хот
ДСА-2025/0691НА-СТА-ТИБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1,323,900.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн *15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;* Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

- 2125040336

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Б.Чимэддорж, нягтлан бодогч Б.Зул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ